

<https://doi.org/10.69561/mjac.v25i49.3831>

Article | Fasc.6

Соёлын үнэт зүйлийн судалгаанд символик интеракционизмын үүднээс хандах нь

Мөнхцэрэнгийн Золзая 

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
✉ zolzaya.m@mnuac.edu.mn

Хураангуй: Соёлын үнэт зүйлийн судалгаанд бэлгэ тэмдэг, бэлгэдэл, нийгмийн харилцан үйлдлийн хамаарлыг авч үзэх нь чухал ач холбогдолтой. Монголын соёлын өв, үнэт зүйлийн талаарх судалгаанд семиотик, символизмын арга зүйг нэлээд хэрэглэж буй ч символик интеракционизмын үүднээс хандах нь цөөн тохиолддог. Энэ баримтлалыг соёлын судалгаанд хэрэглэснээр нийгэм-соёлын өөрчлөлт, нийгмийн бүтцийн хэв маягийг харгалзан илүү тодорхой үр дүнд хүрч болохыг тус өгүүлэлд тодруулахыг зорив.

Ялангуяа түүхэн тодорхой үе, орон зайг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэн, ач холбогдол бүхий соёлын өвийг судлахад тухайн өвийн утга, бэлгэдлийн талаарх өвлөн уламжлагчийн төсөөлөл, тайлбар, ойлголт, байр суурь, тэдгээрт нөлөөлсөн социаль шалтгааныг илрүүлэхэд ерөнхийдөө символик интеракционист хандлага чухал юм.

Түлхүүр үгс: соёлын өв, индекс, нийгмийн харилцан үйлдэл, нийгэм-соёл, интерпретатив интерактивизм, бэлгэ тэмдэг, метасемиотик

On The Application of symbolic interactionism in the study of cultural values

Zolzaya Munkhtseren 

The Research Institute of Culture and Arts, Mongolian National University
of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
✉ zolzaya.m@mnuac.edu.mn

Abstract: It is important to closely examine the relationship between symbols and social interactions in the study of cultural values. While semiotics and symbolism theory and methods are widely used in research on Mongolian cultural heritage and values, there is a need for a more detailed examination from the perspective of symbolic interactionism. Applying this theory in cultural studies would provide a clearer explanation by considering social change and structural patterns.



From the perspective of symbolic interactionism, in studying cultural heritage that represents a specific historical period or space, with its value and significance in nature, society, history, culture, art, and science, involves examining the meaning, symbolism, perceptions, interpretations, understanding, and positions of the inheritor of that heritage. It also includes exploring the social causes and influence. This approach can generally be referred to as a symbolic interactionist perspective.

Keywords: *cultural heritage, index, social interaction, socio-culture, interpretive interactionism, symbol, metasemiotic*

Оршил

Нийгэм, хүмүүнлэгийн салбарын судалгаанд бэлгэдэл, бэлгэ тэмдгийн асуудлыг өргөн авч үздэг. Манайд соёл, урлаг судлал, угсаатны хэл шинжлэл, угсаатны сэтгэл зүй, соёлын антропологи зэрэг салбарын судлаачид уламжлалт зан үйл дэх бэлгэдлийн утгыг илрүүлэн, тайлал хийсэн бүтээл арвин бий. Харин бэлгэдэл дэх субъектив утга нь нийгмийн харилцааг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй болохыг авч үздэг символик интеракционизмын арга зүйг төдийлөн хэрэглэдэггүй нь ажиглагддаг.

Символик интеракционизм нь соёл бол хүмүүсийн харилцан үйлдлээр бий болдог хэмээн үздэг учир соёлын өвийн судалгаанд түгээмэл хэрэглэгдэх бололцоотой. Өөрөөр хэлбэл, аливаа соёл дахь бэлгэ тэмдэг, бэлгэдлүүд нь хувь хүнд итгэл үнэмшил болж улмаар хүмүүсийн зан төлөвт нөлөөлдөг бөгөөд амьдралын туршлагыг нь нөхцөлдүүлдэг (Edwards, M). Иймд энэ өгүүлэлдээ үндэсний соёлын биет болон биет бус өв, үнэт зүйлийн судалгаанд символик интеракционизмыг бүтээлчээр хэрэглэх асуудал, түүний онолын үндэслэл, үндсэн ойлголтуудыг тодруулахыг оролдов. Мөн семиотик, метасемиотикийн онолын тухай хамруулах шаардлагыг харгалзлаа.

Ном, сурах бичигт ихэнхдээ симболыг бэлгэ тэмдэг, бэлгэдэл, дохио тэмдэг гэх боловч соёлын судалгаанд бэлгэдэл гэдэг нь нийтлэг. Үгийн гарлын хувьд “symbol” нь эртний грекийн “σῆμαίον-sēmaion буюу sign-тэмдэг, дохио, марк, им, бэлгэ тэмдэг, дурсамжийн тэмдэг” гэсэн утга илэрхийлдэг. Эртний сэтгэгчид соёл дээр бэлгэ тэмдэг буюу “symbols” (σύμβολον-sýmbolon), харин байгалийн юмс үзэгдэл дээр тэмдэг буюу “sign” гэж ялгаж хэрэглэж байжээ. Судалгааны бүтээлүүдэд symbol-ыг бэлгэдэл, бэлгэ тэмдэг, тэмдэг, тэмдэг бэлгэдэл, утга бэлгэдэл (meaningful symbol) гэж орчуулж ирсэн бөгөөд соёл, зан үйлийн судалгаанд бэлгэдэл, утга бэлгэдэл; symbolic logic-ыг тэмдгийн логик; социологи, дүрслэх урлагт бэлгэ тэмдэг хэмээн нэрлэдэг.

Францын философич Ж.Лакан “симбол”-ыг тэмдэглэгч бөгөөд юмыг орлодог нийгмийн шинжтэй зүйл хэмээн бэлгэднэ гэдэг нь бодит байдлаас зөрүүтэй үйл гэж үзсэн (Гомбосүрэн 2002). Энэчлэн бэлгэдэл, бэлгэ тэмдэг, тэмдэг гэсэн ойлголтуудыг тухайн судлагдахуунаас хамааруулан ялгаатай тайлбарладаг байна. Тухайлбал, соёмбыг титэм-сүлд, төрийн бэлгэдэл, соёлын код болох талаас судалсан бүтээлд бэлгэ тэмдэг, бэлгэдлийн ялгааг тайлбарлахдаа: *Үндсэн хуулийн үзэл санаагаар бол бэлгэ тэмдэг бол хүмүүний оюун сэтгэхүйд гүн шингэсэн эерэг үнэлэмжийн шинжтэй төр, түмний эрхэм дээд итгэл үнэмшил, тэдгээрт суурилсан*

хүндэтгэлийн цогц илэрхийлэл юм. Харин бэлгэдэл нь бэлгэ тэмдгийг эрхэмлэн дээдэлж, тэдгээрт хандах, тэдгээртэй харьцах аливаа ёс журам, зан үйл зэргээр баяжиж, нарийвчлагдсан үйлдэхүйн дүрсэлж, кодлогдсон илэрхийлэл (Чулуунбаатар, Мандах 2023) гэж үзжээ. Ийнхүү судлаачид тухайн объект, дүр, үйлдэл нь бэлгэ тэмдгийн шинжтэй болохыг давталт, ер бусын шинж, эерэг утгатай, хэр тодотгол болохыг нь харгалзан тодорхойлдог байна. Тухайлбал, төрийн далбаа нь тусгаар улс гэсэн бэлгэ тэмдэг бөгөөд монголчуудын төрт ёсны үнэт зүйлд тооцогддог.

Үүнийг тодруулбаас, “Монгол Улсын төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль”-д “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал” гэж заасан бөгөөд төрийн бэлгэ тэмдэг (state symbols) гэдэгт ихэнх улс орнууд эдгээрийг багтаадаг уламжлалтай байна. Харин “Монгол Улсын Төрийн далбаа нь улаан, хөх, улаан хосолсон өнгөтэй байна. Далбааны гурав хуваасны нэгийн хэмжээтэй дундах хэсэг нь мөнх тэнгэрийн хөх, түүний хоёр тал нь мандан бадрахын бэлгэдэл улаан өнгөтэй байна гэж заасан нь мөнх тэнгэрийн хөх, мандан бадрахын улаан нь монголчуудын өнгөний бэлгэдлийн хүрээнд “гүлхүүр бэлгэдэл” байсаар ирсний илэрхийлэл юм (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ 2012), энэ нь хууль, дүрэмд туссанаар улс үндэсний хэмжээний “төрт ёсны бэлгэдэл” гэж хүлээн зөвшөөрөгддөг.

Симболик интеракционизм бол социологийн ухааны онолын чиглэл. Америкийн нийгмийн сэтгэл зүйч, социологич Ж.Х.Блюмер 1937 онд “symbolic interactionism” гэсэн нэр томъёог хэрэглэжээ. Манай судлаачид “symbolic interactionism”-ыг бэлгэ тэмдгийн харилцан үйлдлийн онол, тэмдгийн харилцан үйлдлийн онол, бэлгэдлийн харилцан үйлдлийн арга зүй, бэлгэ тэмдгийн харилцан үйлдлийн онолын үзэл баримтлал хэмээн оноосон байдаг ч бид энд орчуулахгүйгээр хэрэглэлээ. Социологид харилцан үйлдэл нь (interaction) “хэл яриагаар дамжин дохио зангаа, бэлгэ тэмдэг солилцох байдлаар хэрэгжинэ. Утгат бэлгэ тэмдэг нь (meaningful symbol) бусдад ижил ойлгогдож, ижил хариу үйлдэл хийхэд хүргэдэг тэмдэг дохио юм. Хэлний тэмдгийг ашигласнаар сэтгэхүй нь сэтгэгдэл, туршлага, хүлээлтийг байнга удирдана” (Пүрэв 2012) хэмээн тодорхойлжээ. Х.Блюмер “Интеракц буюу харилцан үйлдэл нь хүмүүсийг тодорхойлох нэг төрлийн “баримт” юм. Соёл, нийгмийн бүтэц, нийгмийн үүрэг зэрэг нь хүний үйл ажиллагааны орчин, тогтсон тэмдэгтүүдийн бүрдлийг бий болгодог” хэмээсэн өвөрмөц гаргалгаа хийсэн байх юм.

Америкийн социологич Ч.Х.Кули (1864-1929) “симболик харилцан үйлдэл”, Г.Х.Мид “Би ба нийгмийн үйлдэл” хэмээх ойлголтуудын онолын үндэслэгээг боловсруулсан нь өрнийн социологид чухал үйл явдал болжээ. Ч.Х.Кулийн үзэл баримтлалд Хенри Торо, Ральф Эмерсон нарын трансцендентализм, Уильям Жеймс, Жон Дьюи нарын прагматизмын санаанууд, социологич Херберт Спенсер, Вильгельм Вундтын сэтгэл зүйн онол, В.Дилтейн социологи, Чарльз Дарвины хувьслын онол суурь нь болсон байна. Тэрээр 1920 онд Херберт Спенсерийн бүтээлүүдийг судалж, Мичиганы их сургуульд Жон Дьюитэй хамт ажиллаж байсан нь симболик интеракционизмыг боловсруулахад нь хүчтэй нөлөөлсөн байна. Ч.Х.Кули социологид тохиолдол (кэйс) шинжилгээг статистик үзүүлэлтээс чухалчилсан нь түүний арга зүйн хандлага прагматик, дескриптив байр суурьтайн

илэрхийлэл болно. Ийм хандлагыг соёлын антропологийн оролцон ажиглах аргатай уялдуулах бүрэн боломжтой.

“Би” нь нийгмийн үйлдэлд оролцох замаар хөгждөг. Иймд симболик интеракционизмын гол төлөөлөгч Ч.Х.Кули, Г.Х.Мид нар нийгэм дэх “Би”-гийн төлөвшлийн үе шат, бидний эргэн тойрон дахь ертөнцийг төсөөлж, тайлбарлах замаар бүтээгдсэн толин тусгал, нийгмийн үйлдлийн талаар авч үзжээ. Эндээс соёлын өвийг уламжлагчийн бэлгэдэх социаль шинжийг тодорхойлох маш чухал нь харагдаж байна. Учир нь хүмүүс бид нийгэм, соёлын янз бүрийн нөхцөл байдалд дасан зохицож, тэдгээрийн утга учрыг эргэцүүлэн хариу үйлдэл үзүүлэх, үгүйсгэх, хүлээн зөвшөөрөх эсвэл өөрчлөх хандлагатай. Иймээс симболик интеракционизмд хувь хүний зүгээс бусдын үйлдлийн бэлгэ тэмдэг, бэлгэдэл, утгыг ойлгон хариу үйлдэх үзүүлэх үйл явцыг чухалчилдаг гэж болох юм. Бүхэлдээ хүмүүсийн харилцан үйлдэлд төвлөрч, тэрхүү үйлдлийнх нь утгыг ойлгох, нөхцөл байдлыг нь тодорхойлохын тулд үйлдэгчийн өдөр тутмын үйл ажиллагаанд анхаарч микро түвшинд шинжилдэг онцлогтой аж. Эндээс зарим судлаач бүлгийн соёлын өвөрмөц хэв маягийг бэлгэдлийн уламжлал нь тодорхойлдог (Fine 1979) гэсэн дүгнэлтэд хүрчээ. Иймээс угсаатны бүлгийн соёл, бэлгэдлийг судлахад тэдний харилцан үйлдлийг ажиглан шинжлэх нь үр дүнтэй арга болно.

Энэ өгүүлэлд симболик интеракционист үзэл баримтлалын өөрчлөлт, хэрэглэсэн туршлагыг шинжлэн тоймлохын зэрэгцээ уг онолын давуу тал болон шүүмжлэлт, дутагдалтай талыг ч дурдав. Мөн симболик интеракционизмын онолын үндэслэл, хамрах хүрээ, бэлгэ тэмдэг, бэлгэдэл хэмээх үндсэн ойлголтуудыг тодруулахыг оролдсон болно.

Судалгааны арга зүй

XIX зууны сүүл хагаст өрнөдөд соёлын философи онолууд гарч, соёл судлалын асуудлыг хэлэлцэх болсон. Тухайлбал, философичид соёлын амьдралын нийгмийн философи үндэслэлүүд, байгаль нийгмийн мэдлэгийн уулзварт соёлыг авч үзэх, соёл ба бэлгэдэл, үнэлэмжийн харьцаа, соёлын нийгэмд гүйцэтгэх үүрэг, соёлын түүхэн хэв маягийн тухай онолын баримтлалуудыг дэвшүүлсэн юм. Түүнчлэн нийгмийн философи болон социологийн ухааны арга зүйн шинэчлэл бий болсны нэгэн жишээ бол нийгмийн төлөв байдлыг “хувь хүний хийгээд нөхцөл байдлын нэгдэл” гэж үздэг интеракционизм гэж болно. Энэ нь нийгэм бол хүмүүс хоорондын зохион байгуулалттай, олон хэв маяг бүхий харилцан үйлдлүүд буюу интеракц дээр тогтдог хэмээн, хоёр ба түүнээс дээш тооны хүн симболыг ашиглах замаар нийгэм дэх харилцан үйлдэлд оролцох үйл явцыг мөшгөн судалдаг. Тэгэхээр соёлын өвийн судалгаанд бэлгэдэл, түүний утгыг тодруулах шаардлагатай байдаг нь симболик интеракционизмын үүднээс авч үзэхийн ач холбогдлыг илэрхийлж буй юм.

Симболик интеракционизмын онолын хүрээнд хэрэглэгддэг соёлын үнэт зүйлийн судалгааны аргуудаас дурдвал ажиглах, семиотик, индексжүүлэх, харьцуулах, ярилцлагын арга, контент анализ зэрэг болно. Энд зохиогч симболик интеракционизмын талаарх холбогдох судалгааны бүтээлүүдэд тулгуурлан анализ, харьцуулалт, герменевтик арга зүйг хэрэглэв.

Судалгааны үр дүн

Монголын соёлын үнэт зүйл, биет болон биет бус соёлын өв, уламжлалт ёс заншил, зан үйл, шашин шүтлэгийг семиотик, символик интеракционизмын арга зүйгээр судлахын тулд онолын үндэслэлийг нь тодруулах шаардлагатай юм.

Эрдэмтэд символик интеракционизмыг өөрсдийн шинжлэх ухааны салбар, сэдэвтэй уялдуулан тодорхойлжээ. Тухайлбал, Америкийн социологич Норман К.Дензин символик интеракционизмыг соёл судлалд хэрхэн хэрэглэх арга зүйн талаар бүтээл туурвиж (Denzin 2007), “интерпретатив интерактивизм” гэсэн хандлагыг бий болгожээ. Түүнийхээр бэлгэ тэмдэг, бэлгэдлийн асуудал нь угсаатан, үндэстнүүдийн соёлын харилцаа, ондоошлыг шинжлэх ухааны үндэстэй судлахад чухал ач холбогдолтой юм. Интерпретатив интерактивизм нь субъектийн намтрыг онцолсон чанарын судалгааг голлохын тулд символик интеракционизм, герменевтик, феминизм, постмодернизмыг харгалздаг байна. К.Дензин ярилцлагын арга, намтар судлал нь хүмүүсийн бодит туршлагыг ирлүүлэхэд чухал бөгөөд судалгаанд оролцогч өөрийн тухай ярих явцад “туршлагаа дахин бүтээдэг” гэсэн прагматик ажиглалтад үндэслэжээ. Ийнхүү өрнөдөд үүссэн символик интеракционизмыг ХХ зуунд соёлын судалгаанд хэрэглэх практик нэгэнт тогтож олон бүтээл гарсаар байна.

Манай улсад үндэсний соёлын өв, соёлын хүн судлал, археологи, соёлын онолын судалгаанд бэлгэдэл зүй, семиотикийг түгээмэл хэрэглэсэн байдаг. Тухайлбал, эрдэмтэн С.Дулам монголчуудын бичгийн болон аман эх сурвалжид тулгуурлан үндэсний ижилсэл ондоошлыг илтгэх өнгө, тоо, зүүд зөн совин, дүрс, цаг хугацаа, дохио зангааны бэлгэдлийг судалж цуврал бүтээлүүд туурвисан (Дулам 2019). Эрдэмтэн Л.Батчулуун “Эсгий урлаг тэмдгийн тогтолцоо” хэмээх урлаг судлалын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээлдээ (Батчулуун 2003) монгол эсгий урлалын бэлгэдлийг семиотик судлалын үүднээс ангилж, тэдгээрийн тогтолцооны шинж чанарыг тогтоох судалгаа хийжээ. Ийнхүү гадаад, дотоодын олон эрдэмтэн монголын соёл, угсаатны зүй, утга зохиолын тэмдэг зүй, бэлгэдлийн судалгааг хийж байна. Бид соёлын судалгаанд семиотик, символизмын ялгаа заагийг тодорхой томъёолон илэрхийлэх нь чухал юм.

Семиотик нь тэмдгийн “symbol ба sign”-ыг (σημειωτικός-sēmeiōtikós) судалдаг семиотик судлал нь дохио, биеийн хэлэмж, дуу авиа болон бусад контекстийн тэмдгүүдийн тайлбар, тэмдэглэгч ба тэмдэгтийн харилцааг судалдаг. Семиологичид ямар нэг зүйлээр аль нэг санааг төлөөлүүлэн илэрхийлэх “тэмдэг”-ийг хэрхэн утгажсан, нийгэмд хэрхэн утга оруулдаг талаас нь илэрхийлдэг. Тэмдэг гэж юу вэ? Энэ нь тухайн бодомжид шууд утга агуулсан боловч өөр утгыг илэрхийлдэг эсвэл төлөөлдөг объект, хүн, нөхцөл байдал, үйлдлүүдийг илэрхийлсэн ойлголт. Бидний түгээмэл хэрэглэдэг тэмдэг нь утгын хувьд нийтлэг шинжтэй, харин тусгай тэмдэг нь тухайн зүйлийн агуулгад холбогддог өвөрмөц утга илэрхийлдэг. Тэмдгийн илэрхийлэл, утгын асуудал чухал учир семиотик нь хэл шинжлэлийн онолд тулгуурладаг.

Швейцарын хэл шинжээч Ф.Де.Соссюр хэлийг тэмдгийн систем гэж үзэн хэлний нэгж элемент нь харилцан хамааралт шинж бүхийг илрүүлснээс хойш семиотикийн судалгааны арга зүй нэлээд түгэх хандлагатай болжээ. Семиотикийн

арга зүй нь ертөнцийг бүрдүүлэгч элементүүдийн ил ба далд утга, бүхэллэг ба тусгай, нийтлэг хийгээд ялгаатай талыг илрүүлэн тайлбарлахад чухал ач холбогдолтой. Ф.Де.Соссюр тэмдэглэгдэгч, тэмдэглэгч бүхий хоёрлосон бүтцэт тэмдгийн загвараар “семиологи” арга зүйг боловсруулж байх үед прагматист философич, логикч Чарльз Сандерс Пирс өөрийн тэмдгийн онолын (theory of sign) загварыг бий болгожээ. Тэдний нөлөөгөөр нийгэм, хүмүүнлэгийн салбарт тэмдгүүдийн ангилал зүйн судалгаа хийгдэх болсон байна. Ч.Пирс семиологи, Ф.Де.Соссюр семиотик гэсэн нэршлийг хэрэглэсэн бол М.Лотман (1922-1993) “соёлын семиотик” (cultural semiotics, the semiotics of culture) гэдэг ойлголтыг хэрэглэж, хэл, соёл, бэлгэдэл зэрэг нь тэмдгээр холбогддог хэмээн үзжээ.

Семиотикийг урлаг судлалд өргөн хэрэглэдэг туршлага бий. Тухайлбал, Ф.Де. Соссюрийн семиозисын үзэл баримтлал, Ч.Пирсийн тэмдгийн загварыг бүжгийн урлаг дахь ид шид, зан үйл, шашны илэрхийллийн кодлогдсон хөдөлгөөнийг шинжлэхэд хэрэглэснээр “бүжгийн семиотик” гэсэн чиглэл үүссэн байна (Blanariu 2013). Хөгжмийн урлагт тэмдэг нь ноот, эгшиглээ гэх мэтээр илэрдэг гэж ерөнхийд нь ойлгодог ч Ч.Пирсийн боловсруулсан тэмдгийн гурвалсан илэрхийллээр тэдгээрийн сонсогч, хөгжимчин, хөгжмийн зохиолчийн оюун ухаан дахь хөгжим буюу тэмдэг хэмээн тэдгээрийн харилцаа холбооны нарийн тогтолцоонд авч үзэхийг хөгжмийн семиотик (Reybrouck 2017) гэж нэрлэдэг байна.

Ч.Пирсийн гурвалсан харьцааны загвар нь **төлөөлөл**: тэмдэг үүсгэх хэлбэр (материаллаг байх албагүй); **тайлбарлагч**: тэмдгийн утга учрыг танин мэдсэн субъект; **объект**: тэмдгээр илэрхийлэгдсэн ямар нэг зүйлээр тодорхойлогддог. Энэ нь *тэмдгийг зөөгч*: тэмдгийн хэлбэр; *утга санаа*: тэмдгийг тайлсан утга санаа; *референт* буюу тэмдгээр илэрхийлэгдэж байгаа зүйл” гэсэн агуулгатай бөгөөд тэдгээрийг “семиотик гурвалжин” гэж нэрлэдэг. Тэмдэглэгч нь тэмдэглэгдэгчээс хамааралгүй байдаг зүй тогтолтой.

Тэмдэг, тэмдэглэгчийн асуудал нь үнэлэмжийн утгатай тул Францын хэл шинжээч Р.Годель 1957 онд Ф.Де.Соссюрийн тэмдгийн системийн элемент, үнэлэмжийн харилцааг дараах байдлаар тайлбарлажээ. Үнэлэмж, тэмдэглэгдэгч хоёр нь тэмдгийн утгыг хоёр талаас нь харуулна. Эндээс тэмдэглэгдэгч бол цогц олон үнэлэмжээс тогтсон нийлмэл үзэгдэл мөн гэсэн дүгнэлтэд хүрсэн. Илэрхийллийн тал нь тэмдэглэгч, агуулга нь тэмдэглэгдэгч бөгөөд тэмдэглэгч нь материаллаг ба санаалаг мөн чанартай гэж хэл шинжээчид үздэг. Агуулгын тал нь үнэлэмж, утгат чанар гэсэн хоёр хэсэгтэй ч Ф.Де.Соссюрийн хувьд утгат чанар гэдэг бол ухамсрыг бодит байдалтай холбогч болно (Гомбосүрэн 2010).

Тэмдгийн хэрэглээний нэгэн жишээ бол судалгааны ажилд хэмжилт болдог индекс боловсруулалт. Америкийн философич, логикч, математикч, прагматизм, семиотикийг үндэслэгч Ч.Пирс индексийг бүрдүүлэх шалгуурыг боловсруулахдаа тэмдэг болон объект хоорондын бодит харилцааг чухалчилсан. Объект нь “байх ёстой” юм, индекс нь объектыг “бодит байдалтай” холбодог гэжээ. Индекс нь юмсыг тодорхой илэрхийлдгээрээ дүрсээс ялгаатай. Индексэн тэмдэг нь объект руу чиглүүлж, эмх цэгтэй ангилалд оруулдаг” (Chandler 2021) ач холбогдолтой.

Индексээр илэрхийлэгддэг тэмдгүүд нь далд илэрхийллээрээ уншигчдыг объект руу хандуулах, хайлтыг дөхөм болгох, стандартчилж нэгтгэдэг. Жишээ

нь, номын индексийг газар зүйн нэрийн хэлхээ, хүний нэрийн хэлхээ зэргээр бүрдүүлсэн байдаг бол хөгжлийн индекс, мэргэжлийн индекс, интернэтийн индекс, соёлын ялгааны индекс, хотын индекс, аймаг болон дүүргийн түвшин дэх өрсөлдөх чадварын индекс зэргээр олон зүйл, ангилалтай байна.

Өнөө үед хиймэл оюуны хөгжлийг дагаад соёл судлалд соёлын цифр, код гэсэн тэмдэгтэй холбоотой ойлголтыг хэрэглэх болсон. Туркийн судлаач Женко Гулан өдөр тутмын соёлд цахим хэлбэрээр илэрхийлсэн бие даасан элементүүд бүхий соёлын үнэт зүйлийг агуулсан утгын нэгжийг “соёлын цифр” гэж нэрлэжээ. Соёлын цифр нь дижитал ойлголтоор дамжуулан өдөр тутмын амьдралын соёл, соёлын элементүүдийн гүн утгыг нарийвчлан ойлгох гэдэг утгаар соёлын кодоос ялгаатай (Пак Ци Вань ба бусад 2024) ойлголт юм. Энэхүү кодчилал бол тэмдгүүдийг нарийвчилсан бүтэцтэй болгодог байна.

Тэмдэг, тэмдгийн системийн онолын салбар болох метасемиотик нь хоёрдогч буюу илүү нарийвчилсан утгат тэмдгийг судлах чиглэл юм. Метасемиотик нь семиотикт авч үздэг тэмдгүүдийг шинэ тэмдэг үүсгэхэд хэрхэн ашигладаг, тэмдэг, тэмдгийн систем хэрхэн ажилладгийг судалдагаараа семиотикоос ялгаатай. Метасемиотикт дараах хэдэн баримтлал, чиг хандлага байна. Үүнд, 1/ Метасемиотик нь тэмдгүүдийн нэгдэх, хувирах байдал, янз бүрийн контекстэд тэмдэг ямар утгатай болох эсвэл утгаа алдах үйл явцыг судалдаг. 2/ Нөгөө талаас метасемиотик бол хоёрдугаар эрэмбийн семиотик онол юм. Учир нь тэмдгүүд өөрийн шууд чиг үүргээрээ (утга дамжуулах) шинэ утгыг бий болгодог төдийгүй илүү нарийн семиотик системийн элементүүд болохыг тодорхойлно. Жишээлбэл, уран зохиол эсвэл урлагийн бүтээлийн текстийн шинжилгээ нь метасемиотикийн хүрээнд яригддаг. 3/ Мөн метасемиотик нь соёл ба нийгмийн семиотик судалгаанд чухал үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, тэмдэг бий болох, түүнийг тайлбарлах үйл явцад янз бүрийн нийгэм, соёлын контекст хэрхэн нөлөөлдөг, түүнчлэн тэмдгүүд нь нийгэм, соёлын бодит байдлыг хэрхэн тусгаж, өөрчлөх боломжтойг илрүүлдэг. 4/ Метасемиотикт тэмдгүүдийн семантик (утга) ба прагматик (контекст ба хэрэглээ) талууд, тэдгээрийн хамаарал дахь харилцан үйлчлэлийг авч үздэг байна. Эдгээр хандлагыг нийгэм-соёлын хамаарлын аспектаар авч үзэх судалгаанд харгалзууштай юм.

XX зуунд Н.А.Бердяев, Э.Кассирер, К.Г.Юнг, К.Леви-Стросс нарын философичид бэлгэдэл зүйн онолыг боловсруулж, соёлын социологид символик интеракционизм, функционализм, зөрчлийн онол, этноцентризм нөлөө бүхий байр суурьтай болж иржээ. Эдгээрээс соёлд бэлгэдэл, бэлгэ тэмдэг гол үүрэгтэй учир символик интеракционизмыг чухалчлан үзэж байна.

Соёл нь утга бүхий бэлгэдлийн тогтолцоо, энэ тогтолцоо нийгмийн амьдралд тулгардаг зөрчилт зүйлийг даван туулах үйл хэргийн заавар төлөвлөгөө болдог (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ 2012) гэсэн тодорхойлолт бий. Тэгвэл философийн хүн судлалын төлөөлөгч, Германы философич Э.Кассирер 1923-1929 онд “Символик хэлбэрүүдийн философи” хэмээх гурван цуврал бүтээлдээ “бэлгэдэл нь соёлын элементүүдийг холбогч функц буюу үйл, харин соёл нь бэлгэдлийн ертөнцийг бүтээдэг. Бэлгэдлийн функц нь соёлын янз бүрийн хэлбэрийн өвөрмөц шинжийг агуулдаг хэмээжээ. Символ (бэлгэдэл) гэдэг ойлголт бол И.Кантын априори хэлбэр

гэдэг ойлголтын шинэ хувилбар бөгөөд тодруулж хэлбэл, мэдрэхүйн олон янз байдлын хэлбэрчилсэн синтезийг тэмдэглэгч ойлголт” (Гомбосүрэн, Дорждагва 2010) гэж үзсэн.

Аналитик сэтгэл судлалыг үндэслэгч К.Г.Юнг “Бэлгэдэл бол харьцангуй үл мэдэгдэм, гэхдээ байдгийг нь зөвшөөрдөг, эсвэл зөвшөөрөх шаардлагатай ямар нэг бодит юмыг илэрхийлдэг тэмдэглээ юм уу томъёолол” хэмээсэн (Гомбосүрэн, Цэрэнханд 2015). К.Г.Юнгийнхээр хамтын ухамсаргүй байдал бол бэлгэдлийг тасралтгүй бүтээдэг, харин бэлгэдэлт амьдрал нь янз бүрийн хүн ам, үндэстэн, ард түмэн ертөнцийн далдлаг юмс төдийгүй нөгөө ертөнцийг зөн билгээрээ мэдэрч, тэдгээрт сүсэглэн залбирахтай гарцаагүй холбогддог байна, түүний ийм үндэслэлтэй санааг соёлын өвийн судалгаанд харгалзах нь зайлшгүй байдаг.

Зан үйлийн, соёлын судалгаанд бэлгэдлүүд олон. Нийгмийн харилцан үйлдэл дэх симболуудын утга янз бүрээр тайлбарлагдаж ойлгогддог. Виктор Түрнер зан үйл дэх бэлгэдлийг судлахад нийгмийн бусад олон үйл ажиллагаатай холбон судлахыг зөвлөж, зан үйл өөрийн бүтэц, эмх цэгцтэй байх хэдий ч гадаад хүчин зүйлийг нь, нийгмийн орчныг нь судлах ёстой (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ 2012) гэсэн нь симболик интеракционизмын агуулгатай нэлээд ойролцоо гэж болохоор байна.

Тэмдгийн асуудал бол онтологи, танин мэдэхүйн илэрхийлэл бүхий юм. Соёлын судалгаанд “симбол”-ыг бэлгэдэл, бэлгэ тэмдэг, тэмдэг гэж орчуулах нь түгээмэл байгаа бөгөөд судлагдахуунд холбогдуулан ялгаж хэрэглэх нь оновчтой. Симболизмын семиотик нь бэлгэдлийн хүрээн дэх утга, тэмдгийг буюу бэлгэ тэмдгийн тухай илүү ярьж, семиотик дангаараа бол ерөнхий тэмдэг хэмээгчийн талаар түлхүү илэрхийлж байгаа ялгаа харагдаж байна. Тэмдэг, бэлгэ тэмдэг нь тодорхой утга агуулсан тэмдэглэгээ, үг, дохио зангаа, эд зүйл, өнгө гэх мэтээр илэрч болно. Бэлгэ тэмдэг, тэмдэг нь тэмдэглэгээ, давталт, байр суурийг илэрхийлдэг бөгөөд олон утгатай. Ер нь эерэг утгатай бэлгэдлийг агуулсан тэмдгийг бол бэлгэ тэмдэг гэж ялгаж хэрэглэх нь оновчтой юм. Хувь хүн нийгмийн харилцаа, туршлага дээрээ үндэслэн тэмдгийг тайлбарлаж, түүнд субъектив утгыг оноож байдаг. Жишээлбэл, зарим тэмдгийн утга соёл бүрт ялгаатай тайлбарлагддаг нь соёлын утгын динамик шинж, нийгмийн нөхцөл байдлын нөлөө тусгалыг хамтад нь илэрхийлж буй хэрэг. Мөн үүний тод жишээ бол өнөө үед нийгмийн сүлжээнд сэтгэл хөдлөл, үйлдлийн утга илэрхийлдэг янз бүрийн дүрслэлийг маш олон төрлөөр хөгжүүлэн хэрэглэж, бүхий л харилцаанд хэвшүүлж байгаа болно.

Бэлгэдэлд холбогдох тэмдгүүдийн үүргийг нягталж, ямар утга санаа илэрхийлж байгааг тодруулсны дараа тэмдэг, бэлгэ тэмдгийн аль болохыг нь тодруулан ямар харилцаатай болохыг нь илрүүлснээр уг бэлгэдлийн боломжит утгуудыг тайлбарлах нөхцөл бүрдэнэ.

Сэтгэлгээг төлөвшүүлэхэд “хэл” гол үүрэг гүйцэтгэдэг учир хэлийг хамгийн чухал нийгмийн институт гэж үзжээ. Э.Кассирер соёлын хэлбэр бүрт бэлгэдлээс нь тогтсон ялгаатай хэл байж, тэдгээр нь хэрэглэгддэг талбар, дүрэм, хэл зүйгээрээ бие биеэсээ онцгойрдог (Гомбосүрэн 2010) хэмээсэн нь манай судлаачид соёлын бэлгэдлийн утгыг шинжлэхэд ардын аман зохиол, эх бичиг судлал, хэл бичгийн баялаг хэрэглэгдэхүүнд тулгуурлаж ирснийг үндэслэгээ болгоход тохирох санаа юм.

Соёл нь нийгмийн харилцан үйлдлээр дамждаг бөгөөд хүмүүс өдөр тутмын харилцан үйлдлээрээ соёлын хэм хэмжээ, үнэт зүйл, итгэл үнэмшилд дасан зохицож, өөриймшүүлж эсвэл ялгаатай нөхцөл бүрдүүлж хамтран оршдог хэмээн тайлбарладаг. Ийнхүү соёлын үнэт зүйлийн зангилаа асуудлыг судлахад символизм, семиотик символик интеракционизмын арга зүйг хэрэглэснээр онолын үндэслэлийг өргөн хүрээнд илэрхийлэх ач холбогдолтой.

Хэлэлцүүлэг

Соёл бол иж бүрдэл шинж чанартай зүйл бөгөөд түүнд харилцан бие бие нөхцөлдүүлдэг өөр хоорондоо холбоотой бүрдэл хэсгүүд байхаас гадна нэгж ба бүхлийн хоорондын харилцаа бүхий эмхгүй болон эмхтэй бүрдэл хэсгүүдийн нэгдлээс бүрддэг, нийгэм, хүний амьдрал, үйл ажиллагаанд цогц байдлаар үйлчилдэг зүйл (Цанжид 2022). Энэхүү бүрдэл хийгээд үндэсний соёлын бэлгэдэл, тэмдэг, утга, тайлбар, соёлын шилжилт, соёлын динамик үйл явц, нийгмийн нөлөөллийг символик интеракционизмд нарийвчлан үздэгээрээ чухал ач холбогдолтой юм.

Аливаа нийгэмд соёлыг бүтээгчийн өвөрмөц туршлага, хэтийн төлөвийг тусгасан өөрийн гэсэн тэмдэг, бэлгэдэл, үнэт зүйл, хэм хэмжээ байдаг. Символик интеракционизм нь соёлын өвөрмөц байдал, олон талт байдлыг хүлээн зөвшөөрч, тухайн нийгмийн харилцан үйлдлээр дамжуулан тайлбарладаг тул соёлын үнэт зүйлийн талаарх төсөөлөл, үнэлэмж, илэрхийллийг тодруулахад чухал болно.

Дүгнэлт

Өнөөгийн дижиталчлал нь тэмдгийн тогтолцоог өргөн ашиглаж байгаа бөгөөд олон соёлын харилцан ойлголцлыг дэмжих гол хэрэглэгдэхүүн болж байна. Энэ утгаараа тэмдгийн судалгаа ч өргөжиж байна. Иймд соёлын өв, үнэт зүйлийн судалгаанд символик интеракционизмын үүднээс хандаж, уламжлалт соёл, сэтгэлгээн дэх бэлгэдлийн төрөл, утгыг нийгмийн харилцан үйлдэлтэй нь холбож өргөн агуулгаар авч үзэх нь арга зүйн ач холбогдолтой шинжлэл болно гэж үзэж байна. Энэ онолын баримтлал нь соёл судлал, соёлын үнэт зүйлийн судалгаанд ерөнхий символик дүр төрхийг гаргахад чухал боловч судалгааны хэмжин нотлох тал дээр маргаантай, субъектив үнэлэмж голлодгийг харгалзан эл дутагдлыг хэрхэн өөр хандлагаар нөхөхийг тооцох ч шаардлагатай. Ийм нөхөлт нь судлах зүйлийг семиотик, соёлын социологи, философийн херменевтикийн уулзварт авч үзсэнээр хангагдах бололцоотой.

Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн судалгаанд символик интеракционизмын баримтлалыг харгалзсанаар хувь хүний зүгээс нийгмийн харилцан үйлдлээр соёлын зүйлийг бий болгож, хэрхэн утгажуулж, тайлбарлаж, бие биедээ дамжуулдаг талаар илүү нарийвчлан үзэхэд дөхөмтэй болно.

Судлаачид символик интеракционизмын арга зүйг хэрэглэн мэдээлэл цуглуулахдаа эх сурвалжийн судалгаа хийх, асуулга боловсруулах, ярилцлага хийх (бүтэцчилсэн, хагас бүтэцчилсэн, гүнзгийрүүлсэн), аудио болон видео бичлэг, судалгааны талбарын тэмдэглэл, баримтжуулалт, ажиглалт, биечлэн оролцох гэх мэт арга техник нийтлэг байна. Гэвч бэлгэ тэмдэг, бэлгэдэл, тэмдэг гэсэн

ойлголтуудыг хэрэглэхдээ ялгаа заагийг бүдэг балархай илэрхийлэх нь цөөнгүй тохиолддог нь тус өгүүллийг бичих шалтгаан болсон юм.

Бэлгэдэлт ертөнц ба нийгмийн харилцан үйлдлийн хамаарал, тэдгээрийн утгыг судалснаар соёлын динамик дахь хувь хүний байр суурь, үүргийг нарийвчлах бололцоо бүрдэх төдийгүй хүн байгаль, нийгэм соёлын харилцааг танин мэдэх суурь болох юм.

Санхүүжилт: СУИС-ийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэнд хэрэгжүүлсэн “Монголын эзэнт гүрний үеийн монголчуудын үнэт зүйлс, соёл сэтгэлгээг баримтаар мөшгөхүй” (2022-2024) сэдэвт суурь судалгааны төсөл.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

- Батчулуун, Л. 2003. “Эсгий урлаг тэмдгийн тогтолцоо.” Sc.D дисс., ШУА.
- Бум-Очир, Д., Мөнх-Эрдэнэ Г. 2012. *Нийгэм, соёлын хүн судлалын онолын үүд.* Улаанбаатар: Адмон.
- Гомбосүрэн, Ц. 2002. *Структурализм ба эдүгээ үеийн түрүү философидолт.* Ред. Отгонбаяр, М. Улаанбаатар: Бемби сан.
- Гомбосүрэн, Ц. 2010. *Хэлний философи ба хэл шинжлэлийн философи.* Ред. Отгонбаяр, М., Базаррагчаа, М. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
- Гомбосүрэн, Ц., Дорждагва, Т. 2010. *Өрнөдийн соёлын философи.* Улаанбаатар.
- Гомбосүрэн, Ц., Цэрэнханд, Б. 2015. “Бэлгэдэл зүй бол К.Г.Юнгийн хувьд психоаналитик судалгааны арга ба судлагдахуун мөн нь.” *Философи, Шашин судлал* 17 (437): 14.
- Дулам, С. 2019. “Монголчуудын ижилсэл-ондоошлын тэмдэг бэлгэдлийн судалгаа.” *Тогтвортой хөгжил ба оюуны соёлын өв.* Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Канке В.А. 2022. *Философи. Түүхэн ба онолын хураангуй.* Орч. Нэмэхжаргал, Т., Отгонбаяр, Ж. Улаанбаатар.
- Отгонбаяр, Ж. 2019. *Домгийн символизм ба шинжлэх ухааны рационализм.* Улаанбаатар, 2002. <https://khuldjo.wordpress.com>.
- Пак Ци Вань ба бусад. 2024. *100 түлхүүр үг. Соёлын контендын тайлбар толь.* Ред. Цэнгэл, Д., Одсүрэн, Д., Орч. Дэлгэрцэцэг, Ч., Лхагвасүрэн, Г. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Пүрэв, Ц. 2012. *Чанарын судалгаа: дүрслэхүй, тайлбарлахуй, ойлгохуй.* Ред. Батбаатар, М., Цэцэнбилэг, Ц. Улаанбаатар.
- Цанжид, А. 2022. *Уугуул монгол соёл.* Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.
- Чулуунбаатар, Г., Мандах, Д. 2023. *Соёмбо (титэм-сүлд, төрийн бэлгэдэл, соёлын код).* Улаанбаатар: Линограф.

Гадаад хэлээр:

- Blanariu, Nicoleta Popa. 2013. "Towards a Framework of a Semiotics of Dance." *Comparative Literature and Culture* (Purdue University) 15(1). <http://docs.lib.purdue.edu/clcweb/vol15/iss1/>. <https://doi.org/10.7771/1481-4374.2183>
- Blumer, H. 1986. *Symbolic Interactionism: Perspective and Method*. Englewood Cliffs, NJ: Prentice-Hall.
- Chandler, Daniel. 2021. Semiotics For Beginner 11/23/2021 20:31:17. <http://visual-memory.co.uk/daniel/Documents/S4B/sem02.html> Last modified.
- Denzin, Norman K. 2007. *Symbolic Interactionism and Cultural Studies: The Politics of Interpretation*. Wiley University. <https://doi.org/10.1002/9780470698969>
- Edwards, M. *Symbolic Interactionist View of Culture: An In-depth Explanation*. <https://easysociology.com/sociological-perspectives/symbolic-interactionism/symbolic-interactionist-view-of-culture-an-in-depth-explanation/>.
- Fine, G. A. 1979. "Small Groups and Culture Creation: The Idioculture of Little League Baseball Teams ." *American Sociological Review* 44 (5): 733-45. <https://doi.org/10.2307/2094525>
- Hofstede, Geert. 2001. "Culture's Consequences." *Comparing Values, Behaviors, Institutions and Organizations Across Nations* (Thousand Oaks CA: Sage) Comparing Values.
- Martinez, José Luiz. огноо байхгүй. "A semiotic theory of music: According to a Percean rationale." *The Sixth International Conference on Musical Signification*. https://hugoribeiro.com.br/biblioteca-digital/Martinez-A_semiotic_theory_music.pdf.
- Matthes, Erich Hatala. 2024. *What to Save and Why: Identity, Authenticity, and the Ethics of Conservation*. OUP. <https://doi.org/10.1093/oso/9780197744550.001.0001>
- Munoz-Vinas, Salvador. 2023. *A Theory of Cultural Heritage*. Routledge. <https://doi.org/10.4324/9781003288121>
- Oloidi, Akintunde John. 2020. "The theory of symbolic interactionism in heritage tourism: Assumption, criticism and applications." *Journal of Tourism and Heritage Studies*. <https://doi.org/10.33281/JTHS20129.2020.2.4>.
- Reybrouck, Mark. 2017. "Music and Semiotics: An Experiential Approach to Musical Sense-Making." *Interdisciplinary Approaches to Semiotics*, ed. Asuncion Lopez-Varela Azcarate. <https://doi.org/10.5772/67860>
- Silverman, H. 2014. "Heritage Theory." *Encyclopedia of Global Archaeology*. (eds) C.Smith. New York, NY: Springer. https://doi.org/10.1007/978-1-4419-0465-2_287.